



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/471

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, 17.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нэгдүгээрт хүүхэд” Хөвсгөл аймгийн Хүүхдийн XI чуулганы төлөөлөгч хүүхдүүдээс гаргасан хүсэлтийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүрэлцээ хангамж, дотуур байрны хүүхдүүдийн хоолны чанар хүртээмж, сургалтын хэрэглэгдэхүүн ном гарын авлага, тоног төхөөрөмжийн дутагдал, багш ажилчдын харьцаа хандлага, ялгаварлан гадуурхалт, сургуулийн орчны аюулгүй байдал зэрэг тулгамдаж буй асуудлуудыг нягтлан шалгаж, мэргэжлийн байгууллагыг ажиллуулах, зөвлөмж чиглэл хүргүүлэх, тухайн асуудлуудтай холбоотойгоор өмнө холбогдох байгууллагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүн ямар байсныг тодорхойлох, шаардлагатай бол буруутай этгээдэд хариуцлага тооцох санал боловсруулж батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн хурлыг хуралдуулан удирдамж боловсруулан батлуулж, хэрэгжилт, үр дүнг 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар  
сарын 27-ны өдрийн А/4.7.1-р захирамжийн  
хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн  
дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга,  
Хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч

Аймгийн Санхүү, хяналт дотоод аудитын албаны хяналтын улсын  
байцаагч, дотоод аудитор

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын боловсролын хяналтын улсын  
байцаагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Гэр  
бүл, хүүхэд, залуучууд, жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн  
эрхийн улсын байцаагч

Ажлын хэсгийн нарийн бичиг:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн  
Боловсролын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_